

2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. БҮТЭЦ, ОРОН ТОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Орон тоо: Албаны дарга улсын ахлах байцаагч 1, улсын ахлах байцаагч 1, улсын байцаагч, нягтлан бодогч 1, улсын байцаагч нярав, бичиг хэрэг 1, улсын байцаагч 1 орон тоотойгоор ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр аймгийн төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Засаг даргын дэргэдэх агентлаг юм.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналтын үйл явцыг хараат бус, бие даасан байдлаар үнэлэн дүгнэлт, зөвлөмж өгч, үйл ажиллагааг сайжруулах зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тодорхойлон байгууллагын жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөнд тусгасан ажлуудаа бүрэн хэрэгжүүлсэн. Хамрах хүрээний бүх объектуудад эрсдэлд суурилсан хяналтыг хийн, дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн. Судалгаа шинжилгээ хийн, сургалт явуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашгийг дээшлүүлэх зорилгоор арга зүйн зөвлөмжөөр хангасан. Аймгийн Засаг даргыг үнэн зөв мэдээллээр ханган, удирдлагын тогтолцоог төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулсан. Аймгийн Засаг даргатай байгуулсан 2017 оны үр дүнгийн гэрээний биелэлтийг амжилттай тайлагнаж, А буюу “Маш сайн” үнэлгээ авсан. Аудитын хорооны хурлаар байгууллагын 2017 оны хагас жилийн тайланг хэлэлцүүлж тогтоол гаргуулсан. Байгууллагын шуурхай зөвлөгөөнийг 7 хоног тутам зохион байгуулж, 7 хоногоор төлөвлөж, өгсөн үүрэг даалгаварын биелэлтэд хяналт тавьж, танилцуулан ажиллаж хэвшсэн. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уядуулан Авлигын эсрэг, Эрүүл ирээдүй, биеийн тамир чийрэгжүүлэлтийн төлөвлөгөөнүүдийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан.

2. Байгууллагын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр:

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Төрийн албаны зөвлөлийн программд оруулсан бөгөөд Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүний нөөцтэй холбоотой шаардлагатай мэдээ, судалгааг цаг тухай бүрт нь гаргаж өгсөн.

Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын 2017 оны сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажилласан. 2017 онд албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх төрөл бүрийн сургалт, семинарт хамруулсан. Үүнд:

- Сангийн яамны дотоод аудитын сургалтад 1 улсын байцаагч,
- Зөрчлийн тухай хуулийн сургалтад 5 албан хаагч,
- Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс зохион байгуулсан “Тасралтгүй боловсролын хөгжил” сургалтад 3 улсын байцаагч,
- АЗ сертификаттай сургалтад 2 улсын байцаагч,
- Хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан сургалтад 1 улсын байцаагч,
- Хүний эрхийн комиссоос зохион байгуулсан сургалтад 1 улсын байцаагч

3. Албан хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангах, ажлын үр дүнг үнэлэх, ажлын идэвх санаачлагыг нэмэгдүүлэх чиглэлээр:

Жилийн эцсийн байдлаар төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээг дүгнэж 1300,0 төгрөгөөр шагнаж урамшууллаа. 2 улсын байцаагчийн зэрэг дэвийг ахиулсан. Албан хаагчдын мэргэжлээрээ ажилласан жил, ажлын туршлага, амжилтыг харгалзан, болзол шаардлагыг хангасан 1 хүнийг Сангийн яамны “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр, 1 хүнийг “Аймгийн тэргүүний ажилтан” тэмдгээр, 2 хүнийг аймгийн ИТХ-ын “Хүндэт жуух”-аар тус тус шагнуулсан.

Байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд анхаарч, биеийн тамир, спортын хамтлагийг шинэчлэн байгуулж, ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдарыг чийрэгжүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх биеийн тамир, спортын тэмцээн, арга хэмжээнүүдийг зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. Албан хаагчдыг хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор долоо хоног бүрийн Мягмар гарагт аймгийн Тамгын газрын ажилтнуудтай сагсан бөмбөг, гар бөмбөгөөр хичээллэж байна. 3 улсын байцаагч Булган 2017 МАРАФОН-д амжилттай оролцсон. Мөн хавар, намрын бүх нийтийн их цэвэрлэгээ болон цас цэвэрлэгээнд идэвхтэй оролцож, бүх нийтээрээ мод тарих ажилд оролцсон, аймгийн 80 жилийн ой болон Булган аймагт математикийн улсын 53 дугаар олимпиад зэрэгт сайн дураараа нийт 959,3 мянган төгрөгийн хандив өгсөн.

4. Архив, албан хэрэг хөтлөлтийг сайжруулах чиглэлээр:

Архивын хууль тогтоомжийн дагуу 14 архивын хадгаламжийн нэгж хүлээн авч нөхөн бүрдүүлэлтийг хийсэн. Албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн хэвлэмэл хуудсыг албан хэрэгт ашиглаж, байгууллагын албан хэргийг “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын дагуу хэвийн хөтлөн явуулж байна.

Тайлант онд тус байгууллагад 193 албан бичиг ирснээс 102 хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлж, 106 албан бичгийг холбогдох байгууллага, иргэнд хүргүүлсний 59 нь хариутай албан бичиг байсан.

2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар байгууллагын даргын А тушаал 1, Б тушаал 15-ыг албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын холбогдох заалтуудад нийцүүлэн гаргасан байна.

2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 13 өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног байна.

5. Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр:

Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж нийтдээ 27 шийдвэрийн 35 заалтыг хяналтад авч, байгууллагын жилийн төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Хяналтад авсан захирамжлалын биелэлтийг улирал бүр ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2017 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг гарган хүргүүлсэн.

Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн, Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст ABLE цахим хуудсаар хугацаанд нь хүргүүлж ажилласан.

6. Байгууллагын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:

Байгууллагын өдөр тутмын болон сахүүгийн хяналт шалгалт, аудитын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн актуудыг албан хаагчдад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Авлигын эсрэг 2017 оны төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын хэмжээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны шинэчилсэн жагсаалтын дагуу улсын байцаагчид мэдүүлгээ зохих хугацаанд гаргаж өгсөн.

Улсын байцаагчдаас хяналт шалгалт эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн 46 мэдэгдэл хүлээн авч Шилэн дансны нэгдсэн сайтад мэдээлсэн.

7. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хууль журамд нийцүүлэн олон улсын стандартын дагуу хөтлөн явуулах чиглэлээр:

Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу байгууллагын нягтлан бодох бүртгэлийг Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу

явуулж байна. 2017 оны улирал, жилийн эцсийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг гаргаж, хуулийн хугацаанд зохих байгууллагад хүргүүлэн баталгаажуулж ажилласан. 2017 онд 88963,0 мянган төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэртэй үүнээс цалинд 64879,7 мянган төгрөг зарцуулсан.

Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу байгууллагын нийгмийн даатгалын тайланг сар бүр гаргаж, онлайнаар шивж цаасаар хүргүүлэн баталгаажуулсан. Байгууллагаас тайлант хугацаанд нийт 5 албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлд 7208,5 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварт 5419,1 мянган төгрөг төлсөн.

Байгууллагын орлого, зарлагын гүйлгээг холбогдох стандартын дагуу бүртгэж, сар бүр төсвийн гүйцэтгэлийг гаргаж, жижиг мөнгөн сангийн тайланг гүйцэтгэлээр, материалын тайлан болон санхүүгийн тайланг улирал бүр гаргаж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн баталгаажуулж ажилласан.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу байгууллагын 2018 оны төсвийн төсөл, 2019-2021 оны төсвийн төсөөлөл, 2018 оны төлөвлөгөөний хуваарийг улирал, сараар гаргаж харьяалагдах дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Байгууллагын үндсэн хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хянаж, хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр бүртгэж ажилласан. Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу байгууллагын 2017 оны байдлаар нийт 31 нэр төрлийн 17702,4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тоолсон, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, нөөцийн ашиглалтын байдал, тооллогын дүнг нэгтгэн дүгнэлт гаргасан бөгөөд тооллогоор илэрсэн зөрчил дутагдал үгүй байна. Тооллогын дүнг нэгтгэн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, нөөцийн ашиглалтын байдалд дүгнэлт гаргасан.

Аймгийн Аудитын газраар байгууллагын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж, зөрчилгүй санал дүгнэлттэй ажилласан.

8. Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах

Холбогдох хууль, журмын дагуу шилэн дансны нэгдсэн системд бүтэн жил мэдээлэх 5 мэдээллээс 1 мэдээлэл хугацаа хоцроосон, хагас жилээр мэдээлэх 4 мэдээлэл, улирал бүр мэдээлэх 4 мэдээлэл, сар бүр мэдээлэх 36 мэдээлэл, тухай бүр мэдээлэх 96 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн.

Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын нэр, лого, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, хүний нөөцийн бодлогын ил тод байдлын мэдээлэл, 2017 оны үйл ажиллагааны тайлан, тогтоол, шийдвэрийн мэдээ, мэдээллийн ил, тод байдал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, авилгын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2016 оны ажлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, цаг үеийн мэдээ мэдээллийг аймгийн bulgan.gov.mn цахим хуудсанд нийтэлсэн.

Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах зорилгоор батлагдсан 5 орон тоонд ажиллаж буй албан хаагчдын мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, тухай бүр шинэчилсэн.

Хоёр. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Төлөвлөгөөт хяналт шалгалт

Төсвийн тухай хуулийн 69.3. *"Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна."* заалт, Засгийн газрын 2016 оны 483 дүгээр тогтоол, Аудитын хорооны даргын баталсан тус албаны 2017 оны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн.

Нийт 268,8 сая төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн 111 акт тогтоож, 111,9 сая төгрөгийн зөрчлийг цаашид дахин давтан гаргахгүй байх талаар зөвлөж зөрчлийг арилгуулах 23 албан шаардлага өгч ажилласан.

Нийт тогтоогдсон төлбөрөөс 54465,4 мянган төгрөгийн төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, 208847,3 мянган төгрөгийн төлбөрийг тухайн байгууллагад төвлөрүүлэх, 5487,4 мянган төгрөгийн төлбөрийг хуулийн байгууллагад шилжүүлсэн. Үүнээс 27694,2 мянган төгрөгийг аймгийн төсвийн орлогод, 185118,2 мянган төгрөгийг тухайн байгууллагад төвлөрч, актын биелэлт 83,0 хувьтай, албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна.

Шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг ангилж үзвэл татвар хураамж 21,0 мянган төгрөг, төсвийн хөрөнгийг бусдад зээлдүүлж түр ашиглуулсан 9683,3 мянган төгрөг, зориулалт бусаар зарцуулсан 2963,5 мянган төгрөг, үндсэн баримтгүй зарцуулсан болон данс бүртгэлд тусгаагүй 154309,2 мянган төгрөг, өр авлага үндэслэлгүй хаасан 5533,6 мянган төгрөг, цалин хөлс, томилолт илүү дутуу олгосон 64850,3 мянган төгрөг, ашигласан 10000,0 мянган төгрөг, дутагдсан 114,0 мянган төгрөг, бусад 21325,2 мянган төгрөг байна.

Аудитын хорооны хурлаар төлбөр хариуцагчдаас ирсэн өргөдөл хүсэлтийг хэлэлцүүлж төлбөрөөс чөлөөлсөн. Үүнд Рашаант сумын Соёлын төвийн ажилтнуудад илүү олгосон ур чадварын нэмэгдлийн 792,4 мянган төгрөг, Рашаант сумын Цэцэрлэгийн эрхлэгчид илүү цалин олгосон 803,3 мянган төгрөг, Рашаант сумын сургуулийн захиралд илүү олгосон ур чадварын нэмэгдэл 734,1 мянган төгрөг, Бүрэгхангай сумын Сургуулийн захиралд олгосон ур чадварын нэмэгдэл 627,1 мянган төгрөг, Бүрэгхангай сумын Цэцэрлэгийн ур чадварын нэмэгдэлд олгосон 624,6 мянган төгрөг, Хутаг-Өндөр сумын санхүүгийн албаны нягтлан бодогчид олгосон ажил хавсарсны нэмэгдэл 1468,4 мянган төгрөг нийт дүнгээрээ 5049,9 мянган төгрөгийн төлбөр чөлөөлөгдсөн байна.

Илэрсэн ноцтой зөрчил: Бүрэгхангай сумын төсвийн мэргэжилтэн 2016 онд нэмэлт санхүүжилтийн данснаас 10000,0 мянган төгрөгийг залруулгын гүйлгээ нэртэйгээр анхан шатны баримтгүйгээр хийсэн. Бүрэгхангай сумын нэмэлт санхүүжилтийн дансанд хийсэн шалгалтын материалыг Цагдаагийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлсэн.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт

Үүнд: 1. Гурванбулаг суманд гарсан хонины цэцэг өвчний зардлын гүйцэтгэлд шалгалт хийж Засаг даргын зөвлөлд танилцуулсан.

2. Иргэн Ш.Догсомын хүсэлтээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт шалгалт хийж 80,8 мянган төгрөгийг өргөдөл гаргасан иргэнд олгуулах акт тогтоосон

3. Рашаант сумын ИТХ-ын нарийн бичиг Ц.Оюунбилэгийн өргөдлийн хүрээнд Рашаант сумын ИТХ-д шалгалт хийж 711,4 мянган төгрөгийн нэмэгдлийг нөхөн олгох акт тогтоосон.

4. Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын хүсэлтээр шалгалт хийж дуудлага худалдаа зохион байгуулаагүй худалдсан автомашины үнийн 700,0 мянган төгрөгийг төлүүлэх акт тогтоосон.

5. Хишиг-Өндөр сумын Засаг даргын хүсэлтээр тус сумын Цэцэрлэгт хийсэн шалгалтаар зориулалт бусаар зарцуулсан 497,0 төгрөгийг төлүүлэх, бусад асуудлыг цагдаагийн газарт шилжүүлсэн.

6. Дашинчилэн сумын Цэцэрлэгийн ажиллагсдын өргөдлийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэнхүүнд 1 улсын байцаагч ажиллаж, тус Цэцэрлэгт данс бүртгэлд тусгаагүй 500,0 мянган төгрөгийн хөрөнгө, цалин илүү олгосон 798,5 мянган төгрөгийг төлүүлэх акт тогтоосон.

7. АТГ-ын хүсэлтээр Эрдмийн өргөө цогцолбор сургуульд шалгалт хийж шүүхийн шийдвэрээс дутуу олгосон 359,4 мянган төгрөгийг нөхөн олгох, илүү олгосон амралтын олговор 627,4 мянган төгрөг, хандиваас дутагдуулсан 56.0 мянган төгрөг бүгд 1042,7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож АТГ-т хүргүүлсэн.

8. Сумдын эмч нарын өргөдлийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэнхүүнд 1 улсын байцаагч ажиллаж, эмч эмнэлгийн ажилтнуудад Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5-аар олгох тэтгэмж дутуу олгогдож байгааг нягталж, шийдвэрлэх албан шаардлага өгсөн.

9. Прокурорын газрын хүсэлтээр хорих 439-р ангид хяналт шалгалт хийсэн. Зөрчил илрээгүй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн сар бүрийн хяналт

Аймгийн хэмжээнд төсөв байгууллага 174, сан 3, төрийн өмчит аж ахуйн нэгж 2, эмийн эргэлтийн сан 12, өрхийн эрүүл мэндийн төв 2, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 4 нийт 197 байгууллагын шилэн дансны нэгдсэн сайтад мэдээлэл тавьсан байдалд хяналт тавьж, дүнг Сангийн яаманд хүргүүлэв. Мөн аймгийн ИТХТ, Засаг даргын зөвлөлд танилцуулан ИТХТ-ийн тогтоол, аймгийн Засаг даргын захирамж гаргуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Сумдын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга, Тамгын газрын дарга, иргэдийн хурлын төлөөлөгч, санхүүгийн албаны дарга нарт Шилэн дансны холбоотой дүрэм

журмын хэрэгжүүлэх, хяналт тавих талаар зохин байгуулсан сургалтад 600 гаруй хүн хамрагдсан.

Өмнөх оны актын барагдуулалт:

Өмнөх оны актын үлдэгдлээс 9,1 сая төгрөгийг аймгийн төсөвт оруулсан. Барагдуулалт 95 хувьтай байна

ШШГА-тай 2016 онд тогтоогдсон Хишиг-Өндөр сумын Сум дундын эмнэлгийн нягтлан бодогч асан Мөнх-Эрдэнийн 5577,4 мянган төгрөгийн төлбөр барагдуулах гэрээ байгуулан 2500,0 мянган төгрөгийг барагдуулсан.

Гурав. ДҮГНЭЛТ

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажилаа бүрэн хэрэгжүүллээ. Албаны ажилтнуудын ажлын хариуцлага сахилга, ёс зүйг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд анхаарч дотоодын хяналт тавьж ажиллалаа.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, таслан зогсоох талаар бодлогын чанартай асуудлуудыг аймгийн удидлагууд, холбогдох хэлтэс агентлагт тавьж хамтран ажиллаж байна.

Хяналт шалгалтын үр дүн өсөж, шалгалтанд хамрагдсан байгууллагад зөрчил буурч байгаа ч дотоод хяналт сул, хууль дүрэм, журам, стандартаа судалдаггүй байна.

Дөрөв.САНАЛ

1. Мэргэшүүлэх, дээшлүүлэх хэрэгцээ шаардлагыг орон нутгийн хүний нөөцийн бодлоготой уялдуулан системтэй хэрэгжүүлэх.
2. Туршлага солилцох, хамтын ажиллагааг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах.
3. Төсөв, санхүүгийн хувьд боломжит хэмжээгээр баталж байх, манай аймагт аудиторын орон тоог 2018 оны төсөвт нэмж тусгах
4. Шалгагдаж байгаа байгууллагын дансны хуулгыг холбогдох банк, төрийн сангаас гаргуулан авах эрхийг хуульчлах.
5. Зөрчлийн тухай хуульд эрх бүхий албан тушаалтны жагсаалтад оруулах эсвэл нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн эрх олгох

2017 оны 12 дугаар сарын 25